



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/21 ДУА-2018/85/СТА-ТЦЗ Мандалговь хот

**Төлбөр барагдуулах тухай**

Аймгийн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үнэт цаасны тооцоог **20,000.00** /Хорин мянган/ төгрөгөөр дутуу тооцож, орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д /*төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.*/, аймгийн Засаг даргын 2009 оны 97 дугаар захирамжаар батлагдсан “Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах журам”-ын 3.6-д /*Төлбөрт үйлчилгээ, хураамж хураах тухай бүр хариуцсан ажилтанд үнэт цаас, тасалбарын маягтыг актаар хүлээлгэн өгч орсон орлого, зарцуулалтын тайланг тоглолт болон төлбөрт үйлчилгээ үзүүлсний дараах ажлын 1 өдрийн дотор гаргуулан тооцоо бодож, орлогыг байгууллагын дансанд тушаалгаж байна*/ заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх*/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д /*Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан хөтөлбөр батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй*/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Үнэт цаасны орлого **20,000.00** /Хорин мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх:

Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Өндөршил сумын Соёлын төвийн төсвийн шууд захирагч Т.Мөнхцэцэг, нягтлан бодогч Х.Үнэнтунгалаг нарт хариуцуулав.

**АКТЫГ**

**ТОГТООСОН<sup>1</sup>:**

АУДИТОР:  Т.ОЮУН-ЭРДЭНЭ



**ЗӨВШӨӨРСӨН:**

ЭРХЛЭГЧ:  Т.МӨНХЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ:  Х.ҮНЭНТУНГАЛАГ



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.